

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 05 ДУГААР САРЫН 29-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2024 оны 05 дугаар сарын 29-ний өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3 - 6
<i>1. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	3 - 6

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Инновац, цахим бодлогын байнгын хорооны 05 дугаар сарын 29-ний өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Э.Батшугар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 08 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Тасалсан: Э.Бат-Амгалан, Н.Ганибал, Х.Ганхуяг, Ц.Сэргэлэн, Ч.Ундрэм.

Нэг.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, референт П.Болорцэцэг нар байлцав.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Ж.Чинбүрэн нар үг хэлж, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн тайлбар хийв.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 17 минут үргэлжилж, 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр 11 цаг 25 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Э.БАТШУГАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 05 дугаар сарын 29-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордны “Үндсэн хууль” танхим
11 цаг 08 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Э.Батшугар: Байнгын хорооны гишүүд энэ өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирсэн тул Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулья.

Э.Батшугар гишүүн 28 дугаар тойрог, Т.Доржханд гишүүн 29 дүгээр тойрог, Ц.Идэрбат гишүүн 18 дугаар

тойрог, Б.Саранчимэг гишүүн 22 дугаар тойрог, Н.Учрал сайд 28 дугаар тойрог, Ж.Чинбүрэн гишүүн 23 дугаар тойрог.

Байнгын хорооны ирцийг танилцуулж дууслаа.

Одоо Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулья.

Нэг асуудал байгаа.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Энэ бол эцсийн хэлэлцүүлэг шүү гэж бас тодотгож хэлье.

Шууд хэлэлцэх асуудалдаа орёе.

Нэг.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Ажлын хэсгээ оруулах уу? Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой ажлын хэсгийг танилцуулья.

Б.Батцэцэг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга, С.Тэнгис Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын

зөвлөх, Х.Сүрэнхорол Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Б.Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг гишүүдэд тараасан байгаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу?

Н.Учрал сайдын микрофоныг нээе. Н.Учрал сайдын микрофоныг өгье.

Н.Учрал: Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг Засгийн газраас өргөн мэдүүлсэн.

Тэгээд тухайн үед Сангийн яамнаас тодорхой саналуудыг илгээж тэгээд тэр саналуудыг нь тусгаад Засгийн газрын хурлаар дэмжигдээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулиар ямар нэгэн тийм орон зайд биш виртуал бүсэд буюу одоо ийм цахим орчинд мэдээллийн технологийн компаниуд тодорхой шалгуураа давж бүртгүүлээд, тэгээд бүртгүүлсэн компаниудыг татварын болон татварын бус дэмжлэгээр зах зээлд гарах нөхцөлийг бүрдүүлэхээр ажиллах зорилгыг энэ хуулиар агуулж байгаа.

Тэгэхээр мэдээж энэ хууль гарснаараа e-mongolia дээр мэдээллийн технологийн компаниудыг нэгдсэн байдлаар бүртгэлжүүлж эхэлнэ.

Хувийн хэвшлийн төлөөллөөс бүрдсэн мэргэжлийн байгууллагуудаас бүрдсэн зөвлөл ажиллаад тэр зөвлөл нь тус компани энэ шалгууруудыг хангаж байна уу гэдгээс хамаараад тэр бүсдээ бүртгэж аваад тэгээд бүртгэгдсэн компаниуддаа дэмжлэг үзүүлнэ гэж ингэж ойлгож болно.

Тэгэхээр энэ бүртгэгдсэн компаниуд дээр татварын дэмжлэг үзүүлэх, татварын бус дэмжлэг үзүүлэх дээр тусгагдсан заалтууд дээр Сангийн яам бас нэг тийм тодорхой шалгууруудыг нь илүү тодотгож өгөх шаардлагатай гэж саналаа илгээгээд байгаа.

Тэгэхээр нэгэнт эцсийн хэлэлцүүлэг хийгдэх гэж байгаа учраас зарчмын зөрүүтэй ямар нэгэн санал гаргаж болох тийм эрх зүйн орчин байхгүй байна.

Тийм учраас цаашдаа төсвийн хуулийг дагалдуулаад ирэх оны төсвийг хэлэлцэхэд энэ шалгууруудыг нь тодорхой тусгаж өгөх боломж байгаа учраас үүнийг протоколд үлдээх ёстой.

Мөн мэдээлэл технологийн виртуал бүсийн орон тооны бус зөвлөл, мөн энэ бүсэд тавигдах шаардлага, ажиллах журмыг гүйцэтгэх засаглал өөрөө тодорхойлно.

Тэгэхээр үүн дээрээ шалгууруудыг нь тодорхой босгуудыг нь тавиад явах бололцоо байгаа гэдгийг хэлье.

Ингээд ажлын хэсгээс, Сангийн яамнаас нэмэлт бас тайлбар өгөхийг хүсэж байна.

Э.Батшугар: Ажлын хэсгийн 5 дугаар микрофоныг нээе.

Б.Тэлмүүн: Байнгын хорооны дарга, гишүүдэд өдрийн мэнд хүргэе.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн энэ хуультай холбоотой цахим орчинд мэдээллийн технологийн компаниудыг дэмжих асуудлаар бид татварын болон татварын бус олон дэмжлэгүүд

тусгагдсан. Зарчмын хувьд бид засаг дээр яригдаад дэмжигдсэн.

Яг энэ өнөөдөр яригдаж байгаа хуулийн заалттай холбоотойгоор маш том эрсдэл үүсэж байгаа юм аа.

Яагаад гэхээр томоохон компаниуд татварын өмнөх ашгаа их хэмжээгээр энэ виртуал бүсэд бүртгэлтэй аж ахуйн нэгжүүд рүү хандив нэрээр шилжүүлээд татвар ногдох орлогоо тэг рүү хүртэл буулгаад тэр компани болон ИТ-гийн компани аль аль талдаа татвар төлөхгүй байх ийм цоорхой үүсэх ийм эрсдэлтэй байгаа.

Энэ нь цаашлаад Европын Холбооны хар, саарал жагсаалт руу орох эрсдэлтэй ийм асуудал байгаа.

Тэгэхээр бид өмнө нь барьж байсан жишгийн дагуу энэ дээр тодорхой хэмжээний хязгаарлалт тавихгүй бол энэ дээр одоо юу гэдэг юм 200, 300 тэрбум, их наяд их наяд төгрөгийн хандив тусламж нэрээр гулсаад татвар төлөгдөхгүй байх ийм эрсдэл үүсэж байгаа учраас бид энэ дэмжлэгийг тодорхой хууль дээр хязгаарлалтуудыг нь тавьж өгөх нь зүйтэй гэж ийм санал гарч байгаа.

Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3-д зааснаар нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн энэ заалтыг Байнгын хороодын гишүүд гуравны хоёроос доошгүй нь санал хураалгах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд санал хураалгах боломжтой гэж бидний зүгээс харж байгаа.

Тэгэхдээ мэдээж Улсын Их Хурлын Тамгын газар энэ дээр эцсийн үгийг нь хэлэх байх.

Тэгэхээр хэрвээ энэ асуудал дэмжигдэх боломжгүй, хураалгах боломжгүй гэвэл Байнгын хороо эсвэл Хууль дагаж мөрдөх арга хэмжээний тухай тогтоолоор энэ татвараас зайлсхийх эрсдэлийг нь хаах чиглэлээр хууль боловсруулах чиглэл өгсөн ийм заалтуудыг тодорхой түвшинд нь гаргаж өгөх нь зүйтэй болов уу.

Тэгээд бид үүнийг яах вэ Засгийн газрын түвшинд үүнийг татварын хуулийг хязгаарласан журам гаргах боломжгүй.

Тэгэхдээ энэ асуудлыг өнөөдрийн протоколд тусгагдсанаар чиглэл өгөөд явчихвал ядаж бид дараагийн төсвийн хууль дээр аваад явах ийм боломжтой байна.

Тэгэхгүй бол энэ өөрөө маш том эрсдэлийг дагуулах асуудалтай.

Хуулийг урвуулан ашиглах, татвараас зайлсхийх ийм боломж эрсдэл үүснэ гэж үзэж байна. Баярлалаа.

Э.Батшугар: Ж.Чинбүрэн гишүүний микрофоныг нээе. Ж.Чинбүрэн гишүүний микрофон.

Ж.Чинбүрэн: Засгийн газар өөрөө өргөн барьсан хууль шүү дээ. Тийм ээ. Хуулийн төсөл.

Тэгээд бид чинь энэ 13.4 дээр, энэ хуулийн 13.2, 13.3-т заасан татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална гээд орчихсон.

Тэгэхээр би Н.Учрал гишүүний хэлдэгтэй санал нэг байна.

Төсвийн хууль орохтой холбоотойгоор энэ заалтыг тэр цоорхой үүсэхээс сэргийлэх заалтуудыг журам батлахтай холбоотойгоор Засгийн газар буюу одоо хоёр яам, Инновац, харилцаа холбооны яам, Сангийн яам хоёр ийм саналаа оруулж ирээд энэ хуулийнхаа юун дээр засвар хийгээд явчхаж болох юм биш үү гэж хараад байх юм.

Э.Батшугар: Ямар ч байсан өнөөдөр эцсийн хэлэлцүүлэг явж байна.

Энэ утгаараа ч гэсэн Их Хурал дэг зөрчиж болохгүй. Дэгийн хуулиа.

Гишүүд асуулт авч хариулт авч дууслаа.

Мэдээллийн технологи, үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хаасныг мэдэгдье.

Идэвхтэй оролцсон гишүүд болон ажлын хэсэгт баярлалаа.

Хуралдаан 17 минут үргэлжилж, 11 цаг 25 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД